



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Татварын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 20 нэрийн нийт 9,659,174.51 (есөн сая зургаан зуун тавин есөн мянга нэг зуун далан дөрвөн төгрөг тавин нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, нийт үнийг 3,204,840.43 (гурван сая хоёр зуун дөрвөн мянга найман зуун дөчин төгрөг дөчин гурван мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоож харьяа Татварын хэлтсүүдэд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Татварын ерөнхий газрын балансаас харьяа байгууллагуудын балансад шилжүүлэн
бүртгэх хөрөнгийн жагсаалт

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо шир хэг	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах хугацаа
СҮХБААТАР ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС						
1	Номын шүүгээ	2009/12/15	1	514,320.31	102,864.06	2
2	Тумбочка	2009/12/15	1	187,766.66	37,553.33	2
3	Хувцасны шүүгээ	2009/12/15	1	228,437.50	45,687.50	2
4	Цайны шүүгээ	2009/12/15	1	281,179.68	56,235.94	2
5	Хэлтсийн дарга нарын ширээ	2009/12/15	1	619,660.71	123,932.14	2
6	Дэлгэц dell	12/31/2014	1	379,500.00	75,900.00	2
	ДҮН		6	2,210,864.86	442,172.97	
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС						
7	Бичгийн ширээ	2003/12/18	1	154,280.00	30,856.00	2
8	Байцаагчийн бичгийн ажлын ширээ	2009/12/15	3	1,035,870.00	207,174.00	2
	ДҮН		4	1,190,150.00	238,030.00	
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС						
9	Хүлээлгийн сандал	2009/12/15	2	467,391.30	93,478.26	2
10	Хурлын сандал	2010/06/30	7	732,984.00	146,596.80	2
11	Дагавар ширээ	2010/06/30	1	19,050.00	3,810.00	2
12	Бичгийн шүүгээ	2010/06/30	3	838,200.00	167,640.00	2
	ДҮН		13	2,057,625.30	411,525.06	
ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС						
13	Dell optiplex 7040	2017/05/05	1	2,417,760.00	483,552.00	2
14	Хувцасны модон шкаф	2010/06/300	5	1,397,000.00	279,400.00	2
	ДҮН		6	3,814,760.00	762,952.00	
ДОРНОД АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС						
15	Принтер HP M125A2	2016/12/31	2	1,004,800.00	200,960.00	2
16	Принтер Laser LBP-6030	2016/12/31	2	491,200.00	98,240.00	2
	ДҮН		4	1,496,000.00	299,200.00	
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС						
17	Прожектор	12/27/2012	1	1,890,042.00	378,008.40	2
	ДҮН		1	1,890,042.00	378,008.40	
ДУНДГОВЬ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС						
18	Принтер HP M125A2	2016/12/31	2	1,004,800.00	200,960.00	5
	ДҮН		2	1,004,800.00	200,960.00	
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ТАТВАРЫН ХЭЛТЭС						
19	Бичгийн ширээ	2003/12/18	7	1,079,960.00	215,992.00	2
20	Бичгийн ширээ	2009/07/06	4	1,280,000.00	256,000.00	2
	ДҮН		11	2,359,960.00	471,992.00	
			47	16,024,202.16	3,204,840.43	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		47 (дөчин долоо)	9,659,174.51 (есөн сая зургаан зуун тавин есөн мянга нэг зуун далан дөрвөн төгрөг тавин нэгэн мөнгө)	3,204,840.43 (гурван сая хоёр зуун дөрвөн мянга найман зуун дөчин төгрөг дөчин гурван мөнгө)	